

“МЕРЕКС” ХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

➤ Компанийн танилцуулга

Мерекс ХК нь 2012 онд Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдаж, 2014 оны 8 сард үйлдвэрээ бүрэн угсарч дууссан бөгөөд 2015 оноос бетон зуурмагийн үйлдвэрлэлээ албан ёсоор эхлүүлсэн. Компани нь барилгын материал үйлдвэрлэлийн зах зээлд өрсөлдөх, улмаар бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн хэмжээгээр Монгол Улсад тэргүүлэгч бетон зуурмагийн үйлдвэрлэгч болох зорилготой.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 оны 12-р сард Мерекс ХХК-ийн нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх хүсэлтийг хэлэлцэж, 514 дүгээр тогтоолоор баталж, 2014 оны 1-р сард Монголын хөрөнгийн бирж компанийн үнэт цаасыг бүртгэж авснаар Мерекс хувьцаат компани болсон.

Манай үйлдвэр нь цагт 150 м³ бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай, TW-2500 маркын дэвшилтэд төхөөрөмж бүхий БНСУ-д үйлдвэрлэгдсэн автоматжуулсан бетон зуурмагийн үйлдвэр юм. Мерекс бетон зуурмагийн үйлдвэр нь орон сууцны барилга, зам, нисэхийн зурвас болон бусад бүтээн байгуулалт, барилгажилтанд ашиглагдах MNS1185-98 стандартыг хангасан M100-M500 хүртэлх маркын бетон зуурмагийг үйлдвэрлэнэ.


Алсдаа бетон зуурмаг үйлдвэрлэж түгээхээс гадна нэмүү өртөг шингэсэн бетон хийцийн үйлдвэрлэлийг цогцоор нь хөгжүүлэх зорилготой ба өөрөө өөрийгөө түүхий эдээр хангах стратегийг баримтлан ажиллаж байна.

БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЯВУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ ХУГАЦАА:

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	Жилд	252,000 м ³
	Сард	36,000 м ³
	Ээлжинд	1,200 м ³
	Цагт	150 м ³

➤ Үйлдвэрлэл, борлуулалт

2015 он хэдийгээр барилгын салбарын хувьд хүндрэлтэй жил байсан хэдий ч Мерекс ХК нь нийт 34,668.5 м.куб зуурмаг үйлдвэрлэж, нийт 4.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.




36 харилцагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, хэлцэл байгуулан хамтран ажиллаж чанарын аливаа доголдолгүй, стандартанд нийцсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэн харилцагчдынхаа итгэлийг хүлээн ажиллаж чадлаа.

Энэхүү үйлдвэрлэлийн түвшин нь хүчин чадлын 30% орчмыг ашигласан үзүүлэлт бөгөөд цаашид зах зээлийн нөхцөл байдал, эрэлтээс хамааруулан 3 дахин нэмэгдүүлэх боломжтой.

Байнгын ажиллагаат лабораторыг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг тоноглон, ашиглалтанд оруулсан.

➤ Санхүү, ашигт ажиллагаа

Нийт 4.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийн татварын өмнөх дүнгээр 213.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Татварын дараах дүнгээр Мерекс ХК нь 192.6 сая төгрөгийн ашигтай ажилласан.



Өнгөрсөн онд үйлдвэрийн үйл ажиллагаа эхлээгүй байсантай холбоотойгоор 805.1 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдал үүсээд байсан бол 2015 онд ашигтай ажилласнаар тус дүн 748.2 сая төгрөг болж буурсан байна.

➤ **Компанийн үнэт цаасны мэдээлэл**

Мерекс ХК-ийн үнэт цаас тайлант хугацаанд идэвхтэй арилжигдаж 2016 оны эхний хагас жилд бүрдүүлэх **Монголын хөрөнгийн биржийн ТОП-20** индексийн багцад багтсан болно.

2015 оны 12 сарын 31-ний байдлаар

Үнэт цаас	Арилжсан ширхэг	Үнийн дүн /төгрөг/
Мерекс	1,919,507	170,653,555

Эх сурвалж: www.mse.mn

➤ **Компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах**

Сайн засаглал бүхий компани болох зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл, Монголын Хөрөнгийн биржтэй Компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тунхаг бичиг байгуулж ажиллаж эхлэв.
2. Компанийн өөрийн вэб сайт болон Монголын Хөрөнгийн Бирж, КЗҮЗөвлөлийн компанийн засаглалын портал сайт www.governance.mn вэб сайтуудыг ашиглан хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлэл тогтмол хүргэсэн.
3. СХЗ-ны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журмын дагуу Компанийн үйл ажиллагаа, борлуулалттай холбоотой томоохон гэрээ хэлцэлийн талаар мэдээллийг тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон зохицуулах байгууллагад хүргүүлэн ажилласан.
4. Компанийн танилцуулга хийж, 300 хувь хэвлүүлж, тараасан.
5. 2015 оны 02-р сарын 27-нд Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон Брокер дилерийн компаниудын төлөөлөл "Мерекс" ХК-ийн үйлдвэрийн байранд зочилж компанийн үйл ажиллагаатай танилцсан.
6. Жил болгон зохион байгуулагддаг” Бетон зуурмагийн олон улсын ээлжит 12-р Бага хурал”-д компанийн төлөөлөл оролцсон.
7. “Барилгын материалын бэлтгэн нийлүүлэлтийн үзэсгэлэн”, “Орон сууц 2015 үзэсгэлэн”-нд оролцож, компанийн танилцуулга тараан, оролцогч компаниудтай уулзалт хийсэн.
8. Компанийн нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлүүлэх хүсэлтийг СЗХороо нь 8-р сарын 28-ны өдрийн Зөвлөлийн хурлаараа хэлэлцэж, тусгаарлалтаас чөлөөлөх шийдвэр гаргасан.

➤ **Хүний нөөцийн байдал, сургалт хөгжил**

1. 2015 онд барилгын ажлын улирал буюу 4-11 сард 30-34 хүний бүрэлдэхүүнтэй, барилга зогссон үед 12-р сард 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаа.
2. 2015 онд компанийн 7 ажилтан мэргэшүүлэх болон бусад сургалтанд хамрагдаж сертификатыг авсан. Үүнд:
 - ХАБЭА-ын ажилтныг мэргэшүүлэх сургалтанд компанийн ХАБЭА 2 ажилтан
 - “Тоног төхөөрөмжийн засварчин” –ийн сургалтанд үйлдвэрийн 1 туслах ажилчин
 - Үйлдвэрийн операторчины сургалтад Үйлдвэрийн 1 оператор
 - Үйлдвэрийн засварчины сургалтад Үйлдвэрийн 1 туслах ажилтан
 - Автын засварчин мэргэжил олгох сургалтанд 1 ажилтан
 - Автын засварчины сургалтанд 1 ажилтан тус тус хамрагдсан.

➤ **Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 3-р сарын 30-нд, 84 хувийн ирцтэйгээр хуралдсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. ТУЗ-ийн 2015 оны цалин урамшууллын төсөв батлах
5. Компанийн дүрмийг өөрчлөх
6. Ногдол ашиг тараах эсэх

➤ **Төлөөлөн Удирдах Зөвлөл-ийн үйл ажиллагаа**

“Мерекс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл, удирдлага зохион байгуулалт санхүү, төлөвлөлтийн асуудлаар зайлшгүй шийдвэл зохих асуудлуудыг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргаж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн байдаг орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг хоёр хэлбэрээр хийсэн. Гишүүдийн биечлэн оролцсон хурлыг 3 удаа хийж 15 асуудал, зарим яаралтай шийдэх асуудлыг шийдвэрлэхийн тулд цахилгаан шуудангаар /онлайн/ санал авах хурлыг 2 удаа хийж тодорхой асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ангилан үзвэл:

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд: Компанийн бизнес төлөвлөгөө, их хэмжээний хэлцэл болон борлуулалтын төлбөрт шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан борлуулах зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 7 удаа
2. Санхүү, аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд: Хараат бус аудитын байгууллага сонгох зэрэг санхүү, аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 5 удаа
3. Компанийн удирдлага, зохион байгуулалт: Компанийн ТУЗ-ийн дарга гишүүдийг сонгох, Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах, удирдах ажилтны гүйцэтгэлийн хариуцлага зэрэг удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудлаар 1 удаа
4. ТУЗ-өөс өгсөн даалгавар, чиглэл: ТУЗ-өөс өгсөн даалгавар, чиглэл, төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудлаар 1 удаа

➤ **Нийгмийн хариуцлага, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр**

- Үйлдвэрийн тоосжилт болон үйлдвэрийн явцад хэрэглэгддэг бодис, материалаас шалтгаалан үүсч болох сөрөг нөлөөг бууруулах зорилгоор ажилтнуудад сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг хордлого тайлах бүтээгдэхүүн өгдөг.
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх зорилгоор журмын талаар мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 2015 оны “Үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан хуулийн хугацаанд БОНХАЖЯ-аар баталгаажуулан, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ННХГ-т хүргүүлсэн.

